



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх алба хаагчдийн
албаны бэлтгэл шатны сургалтыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/535 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2024 оны А/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн дүйцүүлэх албыг 2024-2026 онд биеэр дүйцүүлэх хаах хүсэлт гаргаж элссэн алба хаагчдыг "Цэргийн албаны бэлтгэл шатны нэгдсэн сургалт"-д оролцуулах, тэдний хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг ханган 2024 оны 06 дугаар сарын 03 -наас 16-ны өдрүүдэд хамруулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2. Сургалтад хамрагдах бэлтгэл үүрэгтнүүдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэргийн албаны бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулахад шаардагдах 1,790,000 (нэг сая долоон зуун ерин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Цэргийн албаны бэлтгэл шатны сургалтад бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулан, осол зөрчилгүй зохион байгуулж, тайлан, мэдээг журамд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэх, сургалтын дүнгийн талаар 2024 оны 06 дугаар сарын 17 - нд тайлагнахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т даалгасугай.

5. Үйл ажиллагааг зохион байгуулж дүнг 5 хоногийн дотор танилцуулж, зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц.)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200266

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2024
оны сарын 28 өдрийн дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБЫГ БИЕЭР ХААГЧДИЙН
АЛБАНЫ БЭЛТГЭЛ ШАТЫН СУРГАЛТАД
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зарцуулалт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Унааны зардал (sonata-7) газ	4 удаа рейс	1790 х 200 л	358,000
3	Хоол 4 хүн (цэрэг норм)	14 хоног (56 хүн өдөр)	56 х25,000	1,400,000
4	Сертификат	4 хүн	8,000	32,000
Нийт үнэ				1,790,000